Баян-Олгий аймгийн Олгий хотод цэвэрлэх байгууламж шинээр барихаар толовлож байна.

Хуучин байгууламж нь элэгдэж эвдэрснээр хотын бохир ус орчин тойрноо болон Ховд голыг бохирдуулсаар байгаа юм.

-Шинэ байгууламжийг барьж босгох зураг тосол гарсан. Барилгынх нь ажлыг энэ онд улсын тосов болон олон улсын зээл, тусламжаар барихаар толовлож байна. Мон хотын тов замыг шинэчлэх ажил хийгдэх зорилт тавьж байна гэж аймгийн Засаг дарга А.Гылымхан ярилаа.

Харин Олгий хотыг тойруулан vерийн аюулаас хамгаалах далан босгох, Ховд гол дээр шинэ гvvр тавих гэж байгааг олон тvмэн тийм ч сайн дэмжихгvй байгаа бололтой. Учир нь vер бол тэнгэрийн vvлнээс буудаг санамсаргvй тохиролдол, Ховд голын тvвшин далан жилийн омнох тvвшинээсээ нэг метр орчим буусныг мэргэжилтнvvд баталж байгаа. Иймд оноогийн эдийн засгийн хvнд vед «цагаан хэрэм» барих нь амар ажил биш. Мон Ховд гол боломжийн бетон гvvртэй богоод онгорсон дорвон жилд тvvнийг нэмж орготгосон. Иймд эдгээрт зарцуулах хvч хоронгийг байр нь дутагдаж байгаа сургууль, цэцэрлэгvvдэд зориулах нь зvйтэй гэсэн саналууд иргэдээс ирж байгаа ажээ.